

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.05.14



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	6.04%
Монгол 27	2027.07.07	3.50%	6.74%
Хүннү	2028.01.19	8.65%	6.62%
Монгол 29	2029.06.05	7.875%	7.14%
Монгол 30	2030.02.25	6.625%	7.06%
Монгол 31	2031.07.07	4.45%	7.21%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 6.04%-7.14% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	10.01%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.44%
MMC	2026.09.13	12.50%	6.85%
DBM	2026.03.07	11.00%	8.44%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.85%-12.07%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

GC BOND Supermarket

**5 САРЫН ХАМГИЙН
ЭРЭЛТТЭЙ БОНД**

- ДЭД БҮТЭЦ \$10%
- БАНК САНХҮҮ 20%
- УУЛ УУРХАЙ \$11%
- ҮЛ ХӨДЛӨХ 18-20%

ГС Бондын супермаркет нь хөрөнгө оруулагчдадаа бэлэн бондын тасагт байгаа 5 сарын хамгийн эрэлттэй бондуудаа санал болгож байна.

Дэд бүтэц : \$10%
Банк санхүү : ₮20%
Үл хөдлөх : ₮18%-20%
Уул уурхай : \$11%



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж




Бондын өгөөжийн өсөлт нь АНУ-ын төсөвт дарамт учруулж, өрхийн болон тэтгэврийн сангуудыг алдагдалд хүргэж болзошгүй тул улс төрийн нөхцөл байдлыг харгалзан энэхүү шийдвэрийг гаргасан байна. Америкийн засгийн газрын урт хугацааны бондын (T-Bills) өгөөж нь 5.05% хүртэл өссөн билээ.

Эх сурвалж: Tradingview

ХНС бодлогын хүүг хэвээр нь хадгаллаа

АНУ-ын ХНС 2025 оны эхний хагаст бодлогын хүүгээ 4.25–4.5 хувьд хадгалсаар байгаа нь эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж буйтай холбоотой хэмээн төв банкны тэргүүн Жером Пауэлл онцолжээ. Ерөнхийлөгч Трамп хүүг яаралтай бууруулахыг олон нийтэд шахаж байгаа ч ХНС инфляц өндөр, ажилгүйдэл нэмэгдэх эрсдэл зэргээс болгоомжлон бодлогоо өөрчлөхөөс зайлсхийж байна.

Пауэлл: “Бид зөвхөн эдийн засгийн өгөгдөлд үндэслэн, хараат бус байдлаар шийдвэр гаргана” хэмээн мэдэгдсэн бөгөөд энэ нь төв банк улс төрийн дарамтад автахгүй гэсэн дохио юм. Эдийн засгийн өсөлт тогтвортой боловч экспорт-импортын хэлбэлзэл, тарифын нөлөө зэргийг нухацтай ажиглаж байгаагаа ч тус банк илэрхийлсэн байна. Товчхондоо, Холбооны Нөөцийн Сан зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалж, инфляц ба ажилгүйдлийн эрсдэлийг тэнцвэртэй удирдах зорилгоор хүүг бууруулахын оронд хүлээнэсэн байр суурь баримталж байна.



No Inflation, and Prices of Gasoline, Energy, Groceries, and practically everything else, are DOWN!!! THE FED must lower the RATE, like Europe and China have done. What is wrong with Too Late Powell? Not fair to America, which is ready to blossom? Just let it all happen, it will be a beautiful thing!

978 ReTruths 4.16k Likes

5/14/25, 1:43 AM



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

2025 оны 5-р сарын 5-наас 9-ний хооронд Биржийн бус зах зээлд (ББЗЗ) нийт 88,342 ширхэг үнэт цаас 51.84 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр, мөн 1,591 ширхэг үнэт цаас 1.59 сая ам.долларын үнийн дүнтэйгээр арилжигдсан байна. Эдгээрийн дотор анхдагч зах зээлд:

- 23,550 ширхэг үнэт цаас 23.55 тэрбум төгрөгөөр,
- 1,500 ширхэг үнэт цаас 1.5 сая ам.доллараар тус тус арилжаалагджээ.

Харин хоёрдогч зах зээлд:

- 64,792 ширхэг үнэт цаас 28.29 тэрбум төгрөгөөр,
- 91 ширхэг үнэт цаас 91,481.61 ам.доллараар арилжигдсан үзүүлэлттэй байна.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



4 САРЫН
ОНЦЛОХ БОНД

БАНК, САНХҮҮ
18-20.4%

ЭРЧИМ ХҮЧ
19%

УУЛ, УУРХАЙ
\$11%

